

Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээний хүчинтэй байх хугацаатай холбогдуулан шинээр хэрэгжүүлэх арга хэмжээ



2022 оны 6 сарын 22-ны өдөр
Хилийн шалган нэвтрүүлэх,
оршин суух хяналтын газар
Immigration Services Agency of Japan

Өнөөгийн байдал, үндсэн чиглэл

◎ Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газарт өнөөг хүртэл шинэ COVID-19 халдварын тархалтаас болж Япон улсын хилээр нэвтрэн орох хугацаанаас хоцорч байгаа хүнд зориулж хилээр нэвтрэн ороход шаардах оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ (цаашид “зөвшөөрлийн гэрчилгээ” гэх)-ний хүчинтэй хугацааг сунгах арга хэмжээг авсаар ирсэн юм.

◎ Энэ удаад өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, дор дурдсаны дагуу **зөвшөөрлийн гэрчилгээний хүчинтэй хугацааг дахин сунгуулах** (Доорх “Шинээр хэрэгжүүлэх арга” буланг уншина уу) ба 2022 оны 8 сарын 1-ний өдрөөс хойш олгогдсон оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ нь олгосон өдрөөс эхлэн “3 сарын дотор” хүчинтэйд тооцно.

* **Мөн зөвшөөрлийн гэрчилгээ нь олгогдсон үедээ л хилээр нэвтрэх ороход шаардах тухайн нөхцөлд тохирч буйг гэрчлэх бөгөөд, хэтэрхий удаан хугацаанд хүчинтэйд тооцвол хилээр нэвтрэх үеийн нөхцөл байдлаас өөрчлөгдсөн байх магадлалтай тул, дор дурдсан шинээр хэрэгжүүлэх арга хэмжээнээс хойш **зөвшөөрлийн гэрчилгээний хүчинтэй хугацааг дахин сунгуулах боломжгүй**. Харин **өмнөх мэдүүлгийн агуулга нь өөрчлөгдөөгүй бөгөөд 2023 оны 1 сарын 31-ний өдөр хүртэл зөвшөөрлийн гэрчилгээ хүсэх мэдүүлгээ өгөх тохиолдолд (1) Өмнө нь олгогдсон зөвшөөрлийн гэрчилгээ (эх хувь эсвэл хуулбар) болон (2) Хүлээж авах байгууллагаас гаргасан учир шалтгааны тайлбар бичгийг бүрдүүлснээр шинэ зөвшөөрлийн гэрчилгээг шуурхай олгох болно. Дэлгэрэнгүйг [эндээс](#) харна уу.****

Өнөөг хүртэл хэрэгжүүлж байсан арга хэмжээ	Шинээр хэрэгжүүлэх арга хэмжээ
(1) Хамрагдах оршин суух статус Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээтэй холбогдох оршин суух бүх статус	(1) Хамрагдах оршин суух статус Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээтэй холбогдох оршин суух бүх статус
(2) Хамрагдах бүс нутаг Бүх улс, бүс нутаг	(2) Хамрагдах бүс нутаг Бүх улс, бүс нутаг
(3) Хамрагдах оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ 2020 оны 1 сарын 1-ний өдрөөс хойш олгогдсон	(3) Хамрагдах оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ 2020 оны 1 сарын 1-ний өдрөөс хойш олгогдсон
(4) Хүчинтэй байх хугацаа • Олгосон огноо 2020 оны 1 сарын 1-нээс 2022 оны 1 сарын 31-ний өдөр бол → 2022 оны 7 сарын 31-ний өдрийг хүртэл • Олгосон огноо 2022 оны 2 сарын 1-нээс 2022 оны 7 сарын 31-ний өдөр бол → Олгосон өдрөөс эхлэн “6 сарын дотор” хүчинтэйд тооцно	(4) Хүчинтэй байх хугацаа • Олгосон огноо 2020 оны 1 сарын 1-нээс 2022 оны 4 сарын 30-ны өдөр бол → 2022 оны 10 сарын 31-ний өдрийг хүртэл • Олгосон огноо 2022 оны 5 сарын 1-нээс 2022 оны 7 сарын 31-ний өдөр бол → Олгосон өдрөөс эхлэн “6 сарын дотор” хүчинтэйд тооцно
(5) Хүчин төгөлдөр гэж үзэх нөхцөл Зорчиж буй газрынхаа консулын газарт визийн мэдүүлэг өгөх үед, хүлээн авах байгууллага зэргээс “Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ авах үед мэдүүлсэн үйл ажиллагааны агуулгын дагуу үргэлжлүүлэн хүлээн авах боломжтой” гэдгийг бичсэн баримт бичиг ирүүлсэн тохиолдолд Лавлагааны маягт <Хавсралт 1 дээрх оршин суух статус (Жишээ: Техник хүмүүнлэг олон улсын үйл ажиллагаа, оюутан г.м)-ын зориулалттай> Лавлагааны маягт <Хавсралт 2 дээрх оршин суух статус (Жишээ: Япон улсын иргэний гэр бүл, байнгын оршин суугч г.м)-ын зориулалттай> * Хүсэлт гаргаснаас 3 сар өнгөрсөн тохиолдолд дахин шинээр дээрх бичиг баримтыг бүрдүүлнэ үү.	(5) Хүчин төгөлдөр гэж үзэх нөхцөл Зорчиж буй газрынхаа консулын газарт визийн мэдүүлэг өгөх үед, хүлээн авах байгууллага зэргээс “Оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ авах үед мэдүүлсэн үйл ажиллагааны агуулгын дагуу үргэлжлүүлэн хүлээн авах боломжтой” гэдгийг бичсэн доорх баримт бичиг ирүүлсэн тохиолдолд Хавсралт маягт <Хавсралт 1 дээрх оршин суух статус (Жишээ: Техник хүмүүнлэг олон улсын үйл ажиллагаа, оюутан г.м) -ын зориулалттай> Хавсралт маягт <Хавсралт 2 дээрх оршин суух статус (Жишээ: Япон улсын иргэний гэр бүл, байнгын оршин суугч г.м) -ын зориулалттай> * Хүсэлт гаргаснаас 3 сар өнгөрсөн тохиолдолд дахин шинээр дээрх бичиг баримтыг бүрдүүлнэ үү.